



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/349

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.4, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020 хөтөлбөр батлах тухай” 2/01 дүгээр тогтоолын 3.5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүүхдэд ээлтэй аймаг” хөтөлбөр хэрэгжүүлж, бүх нийтээр хүүхдийн эрхийг хүндэтгэх, хүмүүжил төлөвшилд нь анхаарах, хүүхдийн хөгжлийг дэмжих хүрээнд 75 хүүхдийг “Цагаан нуга” хүүхдийн зусланд амруулахад шаардагдах 16,335,000 (Арван зургаан сая гурван зуун гучин таван мянга) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх 16,335,000 (Арван зургаан сая гурван зуун гучин таван мянга) зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100781